

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4 сарын 25 өдөр

дугаар 01


Шарын гол

*Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн  
удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн  
ажлын тайлангийн тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 4 сарын 25 өдөр

дугаар 02


Шарын гол

*Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2016 оны зардлын төсвийн тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ